



ЖИЛИЙН
ТАЙЛАН
2019



IAS INTERNATIONAL
ACCREDITATION
SERVICE®

ISO 9001:2015 Certified Organization

АГУУЛГА

Эрхэм зорилго
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
Компанийн танилцуулга
Санхүүгийн үзүүлэлтүүд
Байгууллагын даатгал
Иргэдийн даатгал
Даатгалын зах зээлийн мэдээлэл
Хүний нөөц
Эрсдэлийн удирдлага
Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа
Удирдлагын баг
Компанийн бүтэц
Хянан нийцүүлэх үйл ажиллагаа
Төлөөлөн удирдах зөвлөл
Хараат бус аудиторын тайлан



ЭРХЭМ ЗОРИЛГО

ХЭТИЙН ЗОРИЛТ

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнэтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.

Байгуулагдсан он

2001

Салбар

19

Ажилтан

90

Төлөөлөгч

117

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагчид аа,

Тэнгэр Даатгал ХХК-ийн жилийн тайлантай танилцаж буй эрхэм харилцагчид, хамтран ажиллагчид, давхар даатгагчид болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийнхээ амар мэндийг эрэн мэндчилье. Бидэнд ололт, амжилт, сорилт авчирсан 2019 оны үр дүнг танилцуулж байгаадаа таатай байна.

Тэнгэр Даатгал компанийн хувьд олон улсын нэр хүнд бүхий хөндлөнгийн Аудитын компаниар санхүүгийн тайлангаа жил бүр хянан баталгаажуулалт хийлгэж үйл ажиллагааныхаа чанарт байнга анхаарч ирсэн билээ. Ийм ч учраас Чанарын олон улсын стандарт болон зохицуулагч байгууллагаас тавигддаг зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ирэхийн зэрэгцээ 2019 онд харилцагчийн үйлчилгээгээ сайжруулах зорилгоор нөхөн төлбөрийн хүсэлтийг онлайн буюу дижитал хэлбэрээр хүлээн авах ажлыг эхлүүлсэн. Ингэснээр олгосон нөхөн төлбөрийн тоо өмнөх жилтэй харьцуулахад 52%-иар өссөн хэдий ч нийт ирсэн хүсэлтийн 80 гаруй хувийг дижитал хэлбэрээр баталгаажуулж шийдвэрлэн нөхөн төлбөр шийдвэрлэх хугацааг ажлын 3 хоногт хадгалж чадлаа. Эдгээр үйл ажиллагааны шинэчлэлтийг бий болгох зорилгоор Харилцагчийн үйлчилгээний төв (Дуудлагын төв)-ийн үйл ажиллагааг шинээр эхлүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээ болон нөхөн төлбөрийн дуудлага хүлээн авах үйлчилгээг уртасгасан цагийн горимд шилжүүлээ. Даатгалын үйлчилгээг цахимжуулах бодлогын хүрээнд онлайн даатгалын edaatgal.mn хуудсаа сайжруулж одоогийн байдлаар 4-н төрлийн даатгалын үйлчилгээг компьютер болон гар утсаа ашиглан авах боломжийг бүрдүүлээ. Мөн бизнесийн бусад салбарын цахим гарцуудыг дэмжиж, тэдэнтэй үйл ажиллагаагаа нэгтгэх зорилгоор CandyPay болон Insur зэрэг аппликейшнуудтай даатгалын үйлчилгээг хослуулан хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

2019 онд компанийн нийт хураамжийн орлого 32%-аар өсч 19.1 тэрбум төгрөгт хүрсэн бол хөрөнгийн хэмжээ 3.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 27.5 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онд даатгалын нөхөн төлбөр олголтын хэмжээ эрс нэмэгдэж 6.0 тэрбум гаруй төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь манай харилцагч иргэд, Аж ахуй нэгж байгууллагуудын санхүүгийн байдалд шууд нөлөөлөх байсан дарамтыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулж чадлаа.

Тэнгэр Даатгал нь дэлхийд тэргүүлэгч давхар даатгагчидтай хамтран ажилласнаар эрсдэл даах чадвараа жил ирэх тусам нэмэгдүүлсээр ирлээ. Бид дэлхийн тэргүүлэгч даатгалын компани болох AIG компанитай хамтран байгууллагуудад учирч болох томоохон эрсдэлүүд дээр хэлэлцүүлэг хийж, шилдэг туршлагыг дотооддоо нэвтрүүлэх зорилгоор Монголын санхүүгийн даатгалын форумыг дөрөв дэх жилдээ зохион байгууллаа.

Компанийн өнөөгийн амжилтад үнэтэй хувь нэмэр оруулж байгаа нийт харилцагчид, хамтран ажиллагчид, бизнесийн түншүүд та бүхэндээ талархал илэрхийлэхийн зэрэгцээ аливаа учирч болзошгүй эрсдэл, хүндрэл бэрхшээлийг хамтдаа даван туулахын төлөө хичээн ажиллахаа Тэнгэр Даатгал компанийн нийт ажиллагчдын өмнөөс илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,

Ж.Мөнхсайхан

Гүйцэтгэх захирал

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА


Тэнгэр Даатгал компани нь анх 2001 онд байгуулагдсан бөгөөд өдгөө Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн 100% хөрөнгө оруулалттайгаар 19 дэх жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Бид харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилладаг харилцагчдын итгэл найдварыг бүрэн хүлээсэн даатгалын салбарын тэргүүлэгч компани юм.

Харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилласнаар тэдний итгэл, найдварыг бүрэн хүлээсэн, хариуцлагатай, ил тод байдлыг эрхэмлэдэг хамгийн сайн засаглалтай даатгалын салбар дахь тэргүүлэгч компанийн нэг юм. Тэнгэр Даатгал ХХК нь санхүүгийн ил тод үйл ажиллагаатай, нийгмийн хариуцлага, хамтын ажиллагааны цар хүрээ, сайн засаглалыг баримтлагч зэргээрээ Монголын даатгалын зах зээлд тэргүүлсээр байх болно. Бид Монгол улс даяар нийт 19 салбар, 117 төлөөлөгч, 30 зуучлагч компани, ХасБанк, ХаанБанк, Монголын Үндэсний Хөрөнгө оруулалтын банк, Богд банк, Тээвэр хөгжлийн банкуудаар даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэн ажиллаж байна.


2019 оны 4-р улирлын байдлаар Тэнгэр Даатгал компани Монгол улсын нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа гадаад, дотоодын томоохон дэд бүтцийн, уул уурхайн төслүүд болон Монголын ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн 50 гаруй хувьд даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


/Сая.төг/




Нийт хураамж




Нийт хөрөнгө




Цэвэр ашиг



Эздийн өмч



Нөөц сан



Цэвэр нөхөн төлбөрийн зардал

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 онд бид олон талт сувгаар дамжуулан бизнесийн салбар бүрт, эрэлт хэрэгцээтэй даатгалын бүтээгдэхүүнийг хүргэж ажиллахыг зорьлоо. Бид иргэн, байгууллагад адил хүртээмжтэй байдлаар даатгалын үйлчилгээг хүргэснээр, нийт 42 мянга гаруй хувь хүний 1.9 их наяд төгрөгийн эрсдэл, 1800 гаруй аж ахуйн нэгжийн 6.6 их наяд төгрөгийн эрсдэлийг даатгалын гэрээгээр шилжүүлэн авсан байна. Энэ дундаа бид нефьтийн салбарын эрсдэлийг даатгах арвин туршлагатай тул, тус салбарын томоохон байгууллагууд Тэнгэр Даатгалыг сонгосон. Мөн уул уурхайн болон сэргээгдэх эрчим хүчний салбарын мега төслүүдийн эрсдэлийг даатган, олон улсын давхар даатгалын зах зээлд шилжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд бид үндэстэн дамнасан корпорациудын зарласан нээлттэй тендерт амжилттай оролцлоо. Олон улсын болон Монголын тэргүүлэх байгууллагуудын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг тул манай компани дэлхийн стандартад нийцэх даатгалын үйлчилгээг байнга сайжруулан даатгуулагч нартаа хүргэсээр байна.

RioTinto

TAVAN SOGB GROUP
Joint efforts - New lo success

AIR CHINA

NOVOTEL
HOTELS, SUITES & RESORTS

Kempinski
HOTELIERS SINCE 1897

MCS
international

TCESO
step by step

MT
GROUP

Clean Energy Asia

Newcom Group
Innovating for success

PORSCHE

Shangri-La
ULANBAATAR

REDPATH

ibis
HOTELS

JACOBS

pwc

MOGHAMMET GROUP

MSM

PETROVIS

TTJVCO
Tavan Tolgoi Joint Venture Company



ДАВХАР ДААТГАЛ

Тэнгэр Даатгал ХХК нь давхар даатгалын чадавхиар Монгол Улсын зах зээлд тэргүүлэгч бөгөөд олон улсын нэр хүнд бүхий давхар даатгалын компаниудтай хамтран ажилладаг.

Даатгалын зах зээл дээрх хамгийн өндөр хамгаалалт болох 12.5 сая долларын үнэлгээ бүхий “Трити” буюу багцын давхар даатгалын хамгаалалттай бөгөөд дараах төрлийн даатгалаар хүлээн авсан бүх эрсдэл шууд давхар даатгалын хамгаалалтад ордог. Бидний хүлээн авдаг Хөрөнгийн даатгал, Барилга угсралтын даатгал, Ачаа тээврийн даатгал, Байгууллагын хариуцлагын даатгал, Ажил олгогчийн хариуцлагын даатгал, Гэнэтийн ослын даатгал, Тусгай зориулалтын машин механизм, Хүнд даацын тээврийн хэрэгслын даатгал болон Мэргэжлийн хариуцлагын даатгалын эрсдэл нь автоматаар шууд давхар даатгалын хамгаалалтанд орж байдаг.

Бид олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Standard & Poor's, Moody's, Fitch Rating болон A.M.Best зэрэг агентлагуудаас А+ буюу түүнээс дээш зэрэглэл бүхий давхар даатгалын компаниуд болон олон жилийн туршлага бүхий давхар даатгалын брокерийн компаниудтай хамтран ажиллаж байна.

Тэнгэр Даатгал ХХК нь 2010 оноос олон улсын нэр хүнд бүхий “Chubb”, 2014 оноос Forbes сэтгүүлийн 500 компанийн дийлэнхийг даатгагч болох “American International Group /AIG/”-тэй тус тус хамтран ажиллаж байгаа бөгөөд 2018 оноос эдгээр давхар даатгалын компанийн Монгол дахь албан ёсны түнш даатгалын компани болсон. Бид олон улсын амжилттай харилцаагаараа дамжуулан дотоодын даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулж байгууллагуудад даатгалын боловсрол, эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг хүргэдэг бөгөөд дотоодын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, дэд бүтэц, уул уурхай гэх мэт бүхий л салбарын эрсдэлийг даатган ажилладаг.





ИРГЭДИЙН ДААТГАЛ

Тэнгэр даатгал компани ердийн даатгалын зуучлалаар 30 гаруй байгууллагатай хамтран ажиллаж байна. Даатгалын зуучлагчаар бид 87,000 гаруй иргэдэд даатгалын үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл хоёр дахин нэмэгдсэн байна.

Тэнгэр даатгал ХХК нь банк зуучлалын үйл ажиллагаагаар Монгол Улсын тэргүүлэгч арилжааны банкууд болох Хас банк, Хаан банк, Төрийн Банк, Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк, Капитрон банкуудтай хамтран ажиллаж, эдгээр банкуудын салбар, нэгжээр дамжуулан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ харилцагчдад түргэн шуурхай хүргэж байна. Хамтын ажиллагааны хүрээнд даатгалын хураамжийн орлого өмнөх оны үзүүлэлттээс 15%-иар өссөн бол даатгуулагчдад олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 32%-иар нэмэгдсэн байна.

Тэнгэр даатгал ХХК нь Монгол Улсын 19 аймгийн төвд нийт 19 салбар, 24 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. 2019 онд орон нутгийн зах зээл рүү чиглэсэн зорилго, зорилтынхоо хүрээнд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Бид тухайн аймаг, орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж өдөрлөг, аян, уулзалтуудад идэвхтэй оролцон иргэд, байгууллагуудад даатгалын талаар сургалт, сурталчилгаа хийж, таниулахад чиглэж ажиллаа. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд салбаруудын харилцагчдын тоо өмнөх жилийн мөн үеэс 26%-иар өссөн. Үүнээс иргэдийн харилцагч 27%, байгууллагын харилцагч 22%-иар тус тус өссөн байна.
- Салбарын ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгын хүрээнд хоёр долоо хоногт нэг удаа онлайн сургалт явуулж, цаг үеийн мэдээ мэдээллээр ханган ажилласан нь оны зорилго, зорилтоо биелүүлэхэд нь ажилтнуудад тодорхой дэмжлэг болж өгсөн.
- Орон нутгийн иргэд байгууллагуудад үзүүлэх даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх хүрээнд Хүүхдийн гэнэтийн ослын даатгал, Иргэдийн гэнэтийн ослын даатгал, Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал зэрэг гурван бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлсэн. Салбаруудын ердийн даатгалын хураамжийн орлого өмнөх оноос 34%, Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого 14%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДЛАГА

Тэнгэр Даатгал ХХК нь 2019 онд Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг анх удаа хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, мөн үйлчилгээ, үйл ажиллагаандаа Харилцагчийн үйлчилгээ авах замналын шинжилгээг (Customer Journey analysis) хийсэн ба тус шинжилгээ, судалгааны үр дүнд үндэслэн Стандарт шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлж, үйл ажиллагааны процессын сайжруулалтуудыг хийлээ.

2019 оны 10 дугаар сард Сөүлийн гудамжинд Харилцагчийн Үйлчилгээний төвийг нээсэн ба тус төв нь 7 хоногийн бүх өдрүүдэд 08:00–22:00 цагийн хооронд харилцагчдад Даатгалын болон Нөхөн төлбөрийн үйлчилгээг хүргэж эхэлсэн. Харилцагчийн үйлчилгээний төв нь компанийн нийт дотуур дугаарыг нэгтгэсэн 1800-1889 дугаарт стандарт дуудлагын үйлчилгээг үзүүлж эхэлсэн. 2019 онд Харилцагчид дуудлагын үйлчилгээнд 6 секундын дотор холбогдож, нийт дуудлагын 91.8%-д амжилттай хариулсан үзүүлэлтийг үзүүлсэн.

Тэнгэр Даатгал ХХК нь харилцагч төвт үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Гадаад улсын иргэн харилцагчдад зориулж англи хэл дээрх даатгалын үйлчилгээг 2019 оны 5 дугаар сараас утсаар үзүүлэх болсон. Энэ нь биднийг сонгон үйлчлүүлдэг гадаад улсын иргэн харилцагчид хэлний бэрхшээлгүйгээр утсаар даатгалын үйлчилгээ авах боломжтой болсон юм.

Харилцагчдын даатгалын нөхөн төлбөрийн үйлчилгээнд зарцуулдаг байсан цаг хугацааг хэмнэх зорилгоор Ослын дуудлагыг онлайнгаар шийдвэрлэх процессийг 2019 оны 5 дугаар сард нэвтрүүлсэн ба нийт ослын дуудлагын 81%-ийг Онлайн процессоор хүлээн авч шийдвэрлэсэн байна.

2019 оны 4 дүгээр сараас эхлэн Харилцагчийн гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журамтай болсон. Тус журам хэрэгжиж эхэлснээр Харилцагчийн гомдлыг бүх боломжит сувгаар хүлээн авч, харилцагчдад ажлын 3 өдөрт хариу мэдээлэл өгдөг болсон.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

2019 онд эдийн засгийн үзүүлэлт сайжирч даатгалын салбарын өсөлт эрчимжсэн жил байлаа. Салбарын нийт хураамж 20 хувиар өссөн нь Гэнэтийн ослын даатгал, Авто тээврийн хэрэгслийн даатгал, Агаарын тээврийн даатгалын хэлбэрүүдын хураамжийн орлого 5,9 тэрбум төгрөгөөс 6,8 тэрбум төгрөг хүртэл өссөнтэй холбоотой. Тэнгэр даатгал компанийн хувьд цэвэр нөхөн төлбөр 28 хувиар өссөний 32 хувийг Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын эзэлсэн байна.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд 90,270 даатгалын гэрээ хийгдэн 19,184 сая төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлого бүрдүүлсэн бөгөөд байгууллагын болон брокерийн суваг, мөн хөрөнгийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгал өссөн нь өнгөрсөн жилийн үзүүлэлттэй харьцуулахад борлуулалтыг 32 хувиар өсгөсөн үзүүлэлт байна.


НӨХӨН ТӨЛБӨР

2019 онд цэвэр нөхөн төлбөр 16.1 хувиар өсч 6,070 сая төгрөгт хүрсэнээр хохирлын харьцаа 59 хувьд хүрсэн. Тээврийн хэрэгслийн даатгал болон 5 сая төгрөгөөс дээш хэмжээний нөхөн төлбөр 2 дахин өссөн зэрэг нь нөхөн төлбөрийн өсөлтөд нөлөөлсөн.

АШИГТ АЖИЛЛАГАА

2019 оны цэвэр ашиг 649 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 66 хувиар буурсан нь томоохон хэмжээний даатгалын нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардлын өсөлт, мөн давхар даатгалд шилжүүлсэн хураамж 52 хувиар өссөн зэрэг үзүүлэлтүүдтэй холбоотой байна.

Бид ашгийн үзүүлэлтээрээ салбартаа наймдугаарт жагссан.





ХҮНИЙ НӨӨЦ

Ажилтнууд маань бидний хамгийн үнэт нөөц бөгөөд тэд байгууллагынхаа ирээдүйг тодорхойлж үнэтэй хувь нэмэрээ оруулан ажиллана гэдэгт итгэлтэй байдаг.

Бид ажилтнууддаа ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг ханган ажиллах нөхцөл боломжыг ханган, ажил мэргэжлийн зорьсон зорилгодоо хүрэхэд нь дэмжих олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал: Сайн сайхан оршихуй хөтөлбөр, тэтгэвэрийн нэрийн данс, цалинтай чөлөө олгох хөтөлбөр, сурч хөгжих, өөрийгөө хөгжүүлэх боломжуудыг санал болгодог.

Ажилтнуудаа мэргэжлийн ур чадвараа ахиулахад нь дэмжиж, олон улсын сургалт, семинарт оролцох, (ACCA, Их Британийн IFOA-ийн актуарчийн шалгалтууд гэх мэт) мэргэжлийн зэргийн шалгалт өгөхөд байгууллагаас шалгалтын төлбөрийг чөлөөлөх зэрэг бүх талын дэмжлэгийг үзүүлдэг.

Япон улсад зохион байгуулагдсан Даатгалын борлуулалтын менежемент, Эрсдлийн менежментийн сургалтанд манай байгууллагын ажилтнуудаа амжилттай суралцсан.

Ажилтнуудаа өсөн дэвших, хариуцлагатай ажиллах, хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг хөгжүүлэхэд нь дэмжлэг болохуйц хамтын гүйцэтгэлийн удирдлагын системийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Цахим шилжилтийн эрин үед зайнаас ажиллах шинэ арга барилыг нэвтрүүлж, технологид суурилсан загварт шилжих аливаа санаачилгыг дэмжиж ажиллахыг зорьж байна. Энэхүү зорилгын хүрээнд бид уян хатан ажлын цагийн горимд шилжин илүү хамтын ажиллагаанд тулгуурласан ажлын загварыг нэвтрүүлэхээр анхаарч ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэл хүлээн авах нь даатгалын бизнесийн үйл ажиллагааны томоохон үүрэг хэдий ч үнэн хэрэгтээ, даатгалын компаниуд эрсдэлийг хүлээн авахдаа урьдчилан тодорхойлсон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд байгаа эсэхийг хянаж, холбогдох бодлогын дагуу шийдвэр гарган ажилладаг. Тэнгэр Даатгал ХХК-ийн эрсдэлийн удирдлагын нэгж нь энэхүү зарчмыг бодит байдалд хэвшүүлэхийн төлөө ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаа, стратеги төлөвлөлтдөө хэвшүүлснээр тогтвортой өрсөлдөх чадварыг бий болгох юм.

Зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) нь Эрсдэл ба төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт (Own Risk and Solvency Assessment, ORSA) -ийн аргачлалыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэнгэр Даатгал ХХК нь зах зээлийн тэргүүлэгчдийн нэгийн хувиар тус компанид хүчин төгөлдөр хэрэгжүүлж буй Эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо үндэслэн ORSA системийг амжилттай хэрэгжүүллээ.

“Эрсдэлийн удирдлагын тогтолцоо” нь холбогдох бодлого, журам, зааврыг зохицуулсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн бичиг баримт юм. Тус тогтолцоо нь гурван шатны хамгаалалтын системд тулгуурласан. Гурван шатны хамгаалалтын системийг хэрэгжүүлснээр нийт ажилтны оролцоогоор дамжуулан эрсдэлийн удирдлагын систем өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанд ажиллах бололцоог бүрдүүлнэ.

- Нэг дүгээр шатны хамгаалалт - Бизнес, нөхөн төлбөр болон бусад дэмжих үүрэг бүхий функцууд өдөр тутмын үйл ажиллагаандаа учрах эрсдэлийг удирдах үүрэгтэй.
- Хоёр дугаар шатны хамгаалалт - Хүлээн авч буй эрсдэл нь стратегитай уялдаж буй эсэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарын зохистой эсэхийг шалгаж, учирч болох эрсдэлийг хянах үүрэгтэй.
- Гурав дугаар шатны хамгаалалт - дотоод хяналтын систем, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад хараат бус, бодит үнэлгээ өгөх үүрэгтэй.



Актуарын үйл ажиллагаа (хураамж, нөөц сан)

Тэнгэр даатгал ХХК нь зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлагын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн актуарчтай болох зорилт тавин ажиллаж боловсон хүчнийг дэмжин бэлтгэж байна.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж, хүрэлцээтэй буюу зохистой хэмжээний нөөц сан байгуулах нь Тэнгэр даатгал ХХК-ийн хувьд нэн тэргүүний ач холбогдолтой бөгөөд зохицуулагч байгууллага болон эрх бүхий байгууллагуудын зүгээс хүрэлцээтэй гэсэн үнэлгээг тогтмол авсаар ирлээ. Жишээ нь Тэнгэр даатгал ХХК нь даатгалын салбартаа манлайлан дэлхийн хамгийн том 4 аудитын компаниудтай сүүлийн 10 жилийн хугацаанд хамтран ажиллаж санхүүгийн тайлан, нөөц сангийн хүрэлцээтэй байдалд үнэлгээ хийлгүүлэн ажилласан байна. 2019 онд Deloitte Onch ХХК-аар санхүүгийн тайлагнал, нөөц сангийн хүрэлцээнд баталгаажуулалт аван ажиллаж байна.

Даатгалын салбарт үнийн өрсөлдөөн маш их бөгөөд энэ нь тус салбарын ирээдүйн хөгжилд бодитой саад учруулж, цаашилбал даатгуулагчдад хүрэх үйлчилгээ, түүний хүртээмж, чанарыг сайжруулах боломжийг хаасаар байна. Гэсэн хэдий ч бид энэхүү байдлыг даван туулахын тулд хураамжаа түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон актуарчийн тооцооллын дагуу санал болгож байна. Даатгалын эрсдэлийг удирдах хүрээнд актуар болон эрсдэлийн удирдлагын зүгээс бүтээгдэхүүнүүд дээр борлуулалтын ажилтнуудад хураамжийн эрхийн төвшинг тогтоон өглөө. Ингэснээр даатгалын салбарын томоохон сорилтын нэг болох үнийн дайнаас сэргийлэх мөн ажилтнуудад ойлгомжтой, тодорхой ажиллах чиглэлд томоохон нэмэртэй байхаар байна



НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант 2019 онд бид нийт 5,439 даатгуулагчдад 5.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгож даатгуулагч, харилцагч нарынхаа санхүүгийн асуудалд томоохон дэмжлэг боллоо. Үүнээс, давхар даатгалын компаниар 377.8 сая төгрөгийг төлүүлсэн бол Тэнгэр даатгал компани 4.6 тэрбум төгрөгийг өөрөө хариуцан олгожээ. 2019 онд нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо өмнөх оныхоос 34%-иар, мөн хүлээн авсан мөнгөн дүн нь 35%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байлаа.

Нөхөн төлбөрийн хэлтэс нь тайлант онд хэдийгээр өдөрт ногдох ажлын ачаалал өмнөх оныхоос дундажаар 16%-иар нэмэгдсэн ч нөхөн төлбөрийн шийдвэр гаргах хугацааг 8%-иар богиносгож, шийдвэрлэлтийн хурдаа нэмэгдүүлсэн ба дундажаар ажлын 2.7 хоногт харилцагчдын нөхөн төлбөрийг шийдвэрлэн амжилттай ажиллаа.

Харилцагчаас ирүүлсэн аливаа даатгалын тохиолдлын дуудлагыг орчин цагийн дэвшилтэт технологид тулгуурлан ослын талаарх баримт, материалыг газар дээрээс цахимаар шууд хүлээн авч зохих заавар зөвлөмжийг цаг алдалгүй өгч ажилласан нь их хотын замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэж буй том ач холбогдолтой ажил боллоо. Харилцагч манай компанийн www.edaatgal.mn хуудсаар нөхөн төлбөрийн хүсэлтээ орон зайг үл хамааран илгээх боломжтойгоос гадна харилцагчид өөрсдөө осол гаргасан даруйд хохирлыг хэрхэн баримтжуулан, баталгаажуулах арга барилд суралцаж даатгалын боловсролдоо ахиц гаргасан.



Түүнчлэн, бид нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх цагаа харилцагчид хүртээмжтэй хүргэх үүднээс 7 хоногийн бүхий л өдрүүдийн 08:00-22:00 цагуудад тохируулан ажиллалаа. Ингэснээр харилцагчид ажлын цагт баригдалгүй даатгалын болоод нөхөн төлбөрийн үйлчилгээг авах боломжийг олгосон билээ.



Бид 2019 онд Хотын төв хэсэгт Харилцагчидад үйлчлэх шинэ төвийг нээж үйлчилгээгээ улам бүр ойртууллаа. Тус төв нь Хотын А зэрэглэлд байрлалтай ба харилцагчид ая тухтай үйлчлүүлэх боломжтой, орчин үеийн Харилцагчийн үйлчилгээний төвийн жишигт нийцсэн төв болсон.



ЖАРГАЛСАЙХАНЫ МӨНХСАЙХАН

Гүйцэтгэх захирал

Ж. Мөнхсайхан нь 2020 оны 1 сараас эхлэн Тэнгэр Даатгал компанийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Жаргалсайханы Мөнхсайхан нь 2014 оны 10-р сараас 2015 оны 12 сар хүртэл Тэнгэр Даатгал ХХК-д Гүйцэтгэх Захирлын орлогчоор ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2010-2014 оны хооронд Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас хөрөнгө оруулсан БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Автономит Улсын нийслэл Үрэмч хот дахь ТианРонг Бичил Санхүүгийн Байгууллагад төслийн зөвлөх, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Ж.Мөнхсайхан нь 2000 оноос 2010 хүртэл ХасБанкинд Салбарын менежер, Салбарын Үйл Ажиллагааны Газрын захирал, Зээлийн Хэлтсийн захирал, Картын Төвийн захирал, Маркетингийн Газрын захирал, Бүтээгдэхүүн Хөгжлийн Хэлтсийн захирал, Хэрэглээний Банкны Хэлтсийн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Ж.Мөнхсайхан нь ХҮДС-ийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Вашингтон хотын Страйер Их сургуулийг төслийн удирдлагын чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



БОЛОРБОЛДЫН ЗАЯА

Андеррайтинг хариуцсан захирал

Б. Заяа нь Тэнгэр Даатгал ХХК-д Андеррайтинг хариуцсан захирлаар 2017 оноос хойш ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт сүүлийн 9 жил ажилласан туршлагатай бөгөөд 2010 онд Энэтхэгийн Даатгалын Академид, 2016 онд Японы Даатгалын Сургуульд даатгалын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн. Заяа нь Мандал Даатгалыг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд байгууллагын даатгалын газар, томоохон төслүүдийг олон улсын давхар даатгалд байршуулах ажлыг хариуцаж байсан. Мөн 2013 онд Дэлхийн Банкнаас хэрэгжүүлсэн Даатгалын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулах төсөлд зөвлөхөөр ажиллаж байсан. Тэрээр АНУ-ын Өмнөд Флоридагийн Их Сургуулийг Маркетинг, Олон Улсын Бизнес чиглэлээр Бакалаврын зэрэгтэй төгссөн.



БАТХУЯГИЙН ОЮУН

Эрсдэл хариуцсан захирал

Б. Оюун нь Тэнгэр Даатгал ХХК-ийн Эрсдэл хариуцсан захирлаар 2020 оны 2-р сараас эхлэн томилогдон ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт 10 жил ажилласан туршлагатай бөгөөд ажлын гараагаа Тэнгэр Даатгал ХХК-д Актуарчаас эхлүүлж, Бизнес хөгжүүлэлтийн хэлтсийн захирал, Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал зэрэг албан тушаалуудыг тус тус хашиж байсан. Түүнчлэн, Монголын Актуарчдын Нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын үүргийг давхар хариуцаж, даатгалын актуарын хөгжилд хувь нэмрээ оруулахаар ажилладаг билээ. Б.Оюун нь ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийг математикч, системийн программист мэргэжлээр төгссөн ба магистрын зэргийг Австрали улсын Мельбурны их сургуульд Актуарын шинжлэх ухааны чиглэлээр хамгаалжээ.



ЖУКОВЫН БААТАРБОЛД

Иргэдийн даатгал хариуцсан захирал

Ж.Баатарболд нь 2020 оны 1 дүгээр сард Тэнгэр Даатгал ХХК-д Иргэдийн даатгал хариуцсан захиралаар томилогдсон. Тэрээр 2004 онд ХасБанкинд Жижиг дунд бизнесийн зээлийн мэргэжилтнээр ажлын гараа эхлүүлж тус банкинд Салбарын захирал, Бүсийн захирал, Салбарын удирдлагын хэлтсийн захиралаар 2020 оны 1 сар хүртэл тус тус ажиллаж, иргэдийн банкны чиглэлээр олон өөрчлөлт, шинэчлэлтийн төслүүдийг амжилттай удирдсан туршлагатай. Мөн ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголбанк, Монголын Банкны Холбооноос хамтран хэрэгжүүлж буй төслийн “Харилцагчид зөвлөх банкны мэргэжилтний сургалт”-ын мастер сургагч багшаар ажилладаг. Жуковын Баатарболд нь Санхүү эдийн засгийн дээд сургуулийг банкны удирдлага мэргэжилээр бизнесийн удирдлагын бакалавр, Люксембургийн Их Гүнт улсын Люксембургийн их сургуулийг банк санхүүгийн мэргэжилээр магистерын зэрэгтэй төгссөн.




БАЛЖИРЫН ТУУЛ

Санхүү хариуцсан захирал

Б.Туул нь 2019 оны 1 дүгээр сараас Тэнгэр даатгал ХХК-ийн Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрээр ХасБанкинд 2002 оноос дотоод аудитор, 2003 оноос Бүртгэл хяналтын хэлтсийн захирал, 2004-2006 онд Төлөвлөлт, тайлангийн хэлтсийн захирал, 2007 онд Санхүү хяналтын хэлтсийн захирал, 2008-2017 онд Санхүү удирдлагын газрын захирал, 2017 оны 2 сараас Бүртгэлийн бодлогын хэлтсийн захирлаар ажиллаж байв. Ажлын гараагаа 1998 онд Хадгаламжийн Банкны Хяналт шалгалтын газарт хянан шалгагчаар эхэлсэн. Б.Туул нь СЭЗДС-ийг Банкны эдийн засагч-санхүүч мэргэжлээр төгссөн.

КОМПАНИЙН БҮТЭЦ





ХЯНАН НИЙЦҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэр даатгал ХХК нь Монголын даатгалын тэргүүлэгч компаниудын нэг болохын хувьд хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чандлан мөрдөж, компанийн сайн засаглалыг бүрдүүлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус компани нь дотоод үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг тодорхойлон үнэлж, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн бэхжүүлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлдэг.

Тус компани нь хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон бодлого, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулан баталсан ба эдгээр баримт бичгүүдийг компанид мөрдүүлэн, бэхжүүлэх зорилгоор комплаенсын удирдлагыг нэвтрүүлсэн.

Түүнчлэн, тус компани нь холбогдох заавар, дүрэм, журмын дагуу үйл ажиллагааны болон комплаенсын тайланг тогтмол Төлөөлөн удирдах зөвлөл болон Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулдаг.

Мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг өөрчлөгдөж буй эрх зүйн болон бизнесийн орчинд нийцүүлэн тогтмол хөгжүүлж, сайжруулах, цаашид олон улсын компаниудын тэргүүн туршлагыг нэвтрүүлэн ажиллах болно.



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гүмэнжавын Цэвэгжав нь 2019 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс ХасБанкны Гүйцэтгэх захирлаар томилогдсон бөгөөд үүнээс өмнө 2011-2013 онуудад ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн (ТНН) Санхүү эрхэлсэн захирлаар, 2015 оны 9 сараас эхлэн ХасБанкны Иргэдийн банк хариуцсан захирал, Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Мөн Г.Цэвэгжав нь 2013 оны 3 дугаар сараас 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэл ХасЛизинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2014-2016 онуудад Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн даргын албыг тус тус хашиж байсан. Тэрээр өмнө нь АНУ-ын Сан Франциско хотод 2008-2010 онуудад Restoration Hardware компанид хөрөнгө зохицуулалтын менежерээр ажиллахдаа тус компанийн хөрөнгө зохицуулалт, эрсдэлийн удирдлагыг хариуцаж байв.

Түүнчлэн Сан Франциско хотод байрладаг Bluefin Associates (PlumSlice) компанид санхүү эрхэлсэн захирлаар, АНУ-ын Дэнвэр хотод байрлах Wagner Equipment компанид 2004-2008 онуудад хөрөнгө зохицуулалтын шинжээч болон олон улсын нягтлан бодогчоор тус тус ажилласан туршлагатай. Г.Цэвэгжав нь АНУ-ын Колорадогийн Их Сургуулийг олон улсын бизнес ба мэдээллийн системийн чиглэлээр бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Режис Их Сургуулийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Г.Эрдэнэбаяр нь 2013 оны 1 дүгээр сараас ХасБанкны Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрээр ажлын гараагаа 2005 онд ХасБанкны эрсдэлийн менежерээр эхэлсэн бөгөөд 2008 онд Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газрын захирал, 2012 онд Санхүүгийн удирдлагын газрын захирлаар ажиллаж байсан. Г.Эрдэнэбаяр нь 2002-2006 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, 2010-2012 онд Японы Олон улсын их сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэргийг санхүүгийн чиглэлээр тус тус хамгаалсан.



ЖАРГАЛСАЙХАНЫ МӨНХСАЙХАН

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Ж. Мөнхсайхан нь 2020 оны 1 сараас эхлэн Тэнгэр Даатгал компанийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Жаргалсайханы Мөнхсайхан нь 2014 оны 10-р сараас 2015 оны 12 сар хүртэл Тэнгэр Даатгал ХХК-д Гүйцэтгэх Захирлын орлогчоор ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2010-2014 оны хооронд Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас хөрөнгө оруулсан БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Автономит Улсын нийслэл Үрэмч хот дахь ТианРонг Бичил Санхүүгийн Байгууллагад төслийн зөвлөх, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Ж.Мөнхсайхан нь 2000 оноос 2010 хүртэл ХасБанкинд Салбарын менежер, Салбарын Үйл Ажиллагааны Газрын захирал, Зээлийн Хэлтсийн захирал, Картын Төвийн захирал, Маркетингийн Газрын захирал, Бүтээгдэхүүн Хөгжлийн Хэлтсийн захирал, Хэрэглээний Банкны Хэлтсийн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Ж.Мөнхсайхан нь ХҮДС-ийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Вашингтон хотын Страйер Их сургуулийг төслийн удирдлагын чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



ЭРИК ВЕРСАВЕЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Эрик Версавел нь Бельги улсын иргэншилтэй ба Антверп-н Их Сургуульд Хуулийн Магистарын зэргийг хамгаалжээ. Тэрээр 1983 онд өөрийн карьерийг Брюсселс Ламберт Банкаас эхэлж байсан ба 1989 онд Бельгээс ББЛ Лондон, Сөүл болон Жакарта-д ажиллахаар явж байв. Тэрээр ING-руу 1998 оны нэгтгэлийн дараа шилжсэн ба ПТ Ай ING Индонез-д Захирлаар орж байжээ. 2000 онд тэрээр ING Шанхай-н Салбар ба Хятадыг хариуцсан гүйцэтгэх захирал, 2004 онд Солонгосыг хариуцсан гүйцэтгэх захиралаар ажилласан ба 2009 онд Европ руу буцан Азийг Хариуцсан захиралаар ажилласан. 2011 онд тэрээр Украин улсыг хариуцсан гүйцэтгэх захирал болсон ба ING Банк ПЖЭсСи-н ТУЗ-н Даргаар ажиллаж байв. 5 жилийн турших улс төр, эдийн засаг, санхүүгийн хямралын дараа тэрээр Ази руу буцаж Монгол Дахь ING Банкны Суурин Төлөөлөгч болжээ. Эрик хөгжин буй болон хямралд буй зах зээлд ажиллаж туршлага хуримтлуулсан нэгэн бөгөөд хэд хэдэн олон улс хоорондын бизнесийг удирдаж олон улсын харилцагч нартай харилцаа холбоо тогтоон ажиллаж байсан. Тэрээр өөрийн карьерийн хугацаанд ING-д болон иргэний нийгэмд цөөнгүй удирдах албан тушаалыг хашиж байв. Жишээ хэлвээс, Хятад дахь Бенелуксийн Худалдааны Танхимын (БенЧам)-н Дарга, Украин дахь Гадаадын Банкнуудын Дарга байсан ба 2017 оны 3 дугаар сард тэрээр Монгол дахь Америкийн Худалдааны Танхимд (АмЧам) Санхүүгийн Хороог үүсгэн байгуулсан.

ХАСБАНК

Иргэдийн болон Бизнес Банк

ХАСЛИЗИНГ

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ

ТЭНГЭР ДААТГАЛ

Даатгал

ТЭНГЭР
САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

ТЭНГЭР КАПИТАЛ

Хөрөнгө оруулалт

ГЛАШИЕР АССЕТ

Хөрөнгийн менежмент

ТИАНРОНГ

Бичил санхүү





Хараат бус аудиторын тайлан

Тэнгэр Даатгал ХХК-ын Хувьцаа эзэмшигч танаа,
Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид “Компани” гэх) -ын 2019 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Компанийн удирдлага бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэлд агуулагдсан мэдээллүүд орох бөгөөд санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой. Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн мэдэгдэх зүйл байгаагүй болно.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл аудиторын дүгнэлт болон санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулдаг ба уг тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь манай аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэсэн байдаг. Хэдий тийм боловч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компанийг үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.

Ш.Норжинбат
Захирал, МНБ
Делоитт Онч Аудит ХХК
2020 оны 3 сарын 30



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2019 ОНЫ 12 САРЫН 31
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2019	2018
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,500,011	2,407,902
Хугацаат хадгаламж	18,128,134	14,393,796
Урвуу репо хэлцэл	1,302,422	-
Засгийн газрын ба компанийн бонд	-	937,138
Дансны ба бусад авлага	1,001,364	1,237,877
Орлогын албан татварын авлага	23,752	-
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	746,209	622,829
Давхар даатгагчийн орлогод тооцоогүй нөөц	2,961,995	2,483,704
Урьдчилж төлсөн зардал	135,865	177,776
Бараа материал	85,948	88,342
Хойшлогдсон татварын хөрөнгө	15,000	15,546
Үндсэн хөрөнгө	1,243,827	1,148,583
Биет бус хөрөнгө	124,391	123,072
Нийт хөрөнгө	27,268,918	23,636,565
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Даатгалын гэрээний нөөц сангууд	15,463,837	12,001,159
Дансны ба бусад өглөг	2,173,772	2,646,087
Орлогын албан татварын өглөг	-	7,275
Нийт өр төлбөр	17,637,609	14,654,521
Эзэмшигчийн өмч		
Хувьцаат капитал	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Хуримтлагдсан ашиг	4,501,309	3,852,044
	9,631,309	8,982,044
Нийт өр төлбөр ба эзэмшигчийн өмч	27,268,918	23,636,565

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2019 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2019	2018
Орлогод тооцсон хураамж		
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	16,733,014	12,483,965
Давхар даатгагчид ногдох хураамж	(6,506,627)	(4,271,568)
Орлогод тооцсон цэвэр хураамж	10,226,387	8,212,397
Нөхөн төлбөрийн зардал		
Нөхөн төлбөрийн зардал	(6,372,970)	(5,407,720)
Давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр	302,798	1,857,354
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(6,070,172)	(3,550,366)
Даатгалын үйл ажиллагааны цэвэр орлого	4,156,215	4,662,031
Санхүүгийн ба бусад орлого	2,594,225	2,466,021
Бусад (гарз) ба олз	(8,876)	(7,090)
Борлуулалт, ерөнхий ба удирдлагын зардал	(5,856,979)	(4,998,764)
Татварын өмнөх ашиг	884,585	2,122,198
Орлогын татварын зардал	(235,320)	(230,394)
Тайлант жилийн цэвэр ашиг	649,265	1,891,804
Бусад иж бүрэн орлого	-	-
Нийт иж бүрэн орлого	649,265	1,891,804



ХАЯГ:

Сити Центр 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5
Бага тойруу /14200/, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Ш/х-48/258
Утас: (976) - 18001889
И-мэйл: Insurance@tengerinsurance.mn
Веб: www.tengerdaatgal.mn

